



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Адаацаг сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/14/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Мандалговь хот 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Narantsatsralkh@audit.gov.mn">Narantsatsralkh@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:batsaikhant@audit.gov.mn">batsaikhant@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: <a href="mailto:Doljinsurend@audit.gov.mn">Doljinsurend@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт .....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
СХС	Сум хөгжүүлэх сан
БХС	Байгаль хамгаалах сан
ОННТ	Орон нутгийн нэгтгэсэн тайлан



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.03.25 № 82

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020893

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>		930,893.6	1,434,089.9
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	3а, 3б	103,929.1	403,205.6
33	<b>АВЛАГА</b>	5а, 5б, 6а, 6б	295,857.5	472,159.0
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	8а, 8б, 8в	531,107.0	558,725.4
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>		3,399,102.5	3,758,303.8
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	12а, 12б, 12в	3,399,102.5	3,758,303.8
39200	<b>Биет хөрөнгө</b>		3,326,398.5	3,685,749.8
39300	<b>Биет бус хөрөнгө</b>	13	72,704.0	72,554.0
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>		4,329,996.1	5,192,393.8
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>		33,663.5	21,193.5
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	15а, 15б	33,663.5	21,193.5
41300	<b>Өглөг</b>	17а, 17б	33,663.5	21,193.5
5	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>		4,296,332.6	5,171,200.3
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>		4,296,332.6	5,171,200.3
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		1,874,399.9	1,874,399.9
51200	<b>Хуримтлагдсан үр дүн</b>		881,299.9	1,756,167.5
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		1,540,632.9	1,540,632.9
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		4,329,996.1	5,192,393.8

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>		3,427,234.2	4,025,063.1
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>		59,403.5	274,263.7
110	<b>Орлогын албан татвар</b>		42,185.4	31,099.5
1100	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>		42,185.4	31,099.5
113	<b>Хөрөнгийн албан татвар</b>		1,395.0	36,803.0
118	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>		15,823.1	206,361.2
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	1а, 1б	554,775.6	1,124,532.7
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>		554,775.6	1,124,532.7
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		2,813,055.1	2,626,266.7
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	2а, 2б	3,019,190.2	3,157,050.5
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		3,019,190.2	3,157,050.5
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		2,236,583.1	3,034,864.0
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		1,269,036.9	1,341,919.3
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		155,028.3	173,934.6
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		169,012.7	188,496.4
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		58,190.7	121,796.2
2105	<b>Нормативт зардал</b>		84,099.7	434,417.6
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		42,287.0	36,989.8
2107	<b>Томилолт, зочны зардал</b>		6,169.0	3,816.0

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		59,072.5	34,269.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		393,686.3	699,224.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		782,607.1	122,186.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		408,044.0	868,012.6
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		100,328.4	6,644.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		307,715.7	861,367.6

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,993,971.5	0.0	3,993,971.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-5,354.5	0.0	-5,354.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,988,617.0	0.0	3,988,617.0
9	Тайлант үеийн үр дүн	307,715.7	0.0	307,715.7
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,296,332.6	0.0	4,296,332.6
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,296,332.6	0.0	4,296,332.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	13,500.0	0.0	13,500.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,309,832.6	0.0	4,309,832.6
19	Тайлант үеийн үр дүн	861,367.6	0.0	861,367.6
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,171,200.3	0.0	5,171,200.3

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		3,018,746.8	2,882,155.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО		59,403.5	274,263.7
110	Орлогын албан татвар		42,185.4	31,099.5
1100	Хувь хүний орлогын албан татвар		42,185.4	31,099.5
113	Хөрөнгийн албан татвар		1,395.0	36,803.0
118	Бусад татвар, төлбөр, хураамж		15,823.1	206,361.2
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		12,582.2	12,958.9
1181	Газрын төлбөр		3,240.9	2,285.5
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр		0.0	191,116.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		146,288.2	199,712.4
120	Нийтлэг татварын бус орлого		146,288.2	199,712.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		2,813,055.1	2,408,179.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,797,758.3	2,402,446.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,797,758.3	2,402,446.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,015,957.1	2,274,898.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,269,216.8	1,347,877.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		155,119.4	173,843.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		169,012.7	188,757.4
2104	Хангамж, бараа материалын зардал		75,647.1	89,208.8
2105	Нормативт зардал		77,157.4	248,354.3

2106	Эд хогшил, урсгал засварын зардал		96,169.2	35,358.7
2107	Томилолт, зочны зардал		6,169.0	3,816.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		59,342.5	37,276.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		108,123.0	150,405.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		781,801.2	127,548.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		220,988.5	479,708.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		172,695.0	98,432.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		172,695.0	98,432.2
2200	Догоод эх үүсвэрээр		172,695.0	98,432.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-172,695.0	-98,432.2
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-85,500.0	-82,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		85,500.0	82,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		-37,206.5	299,276.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		141,135.6	103,929.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		103,929.1	403,205.6

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,393,373.7	2,165,945.3
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,171,875.8	2,030,547.1
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,119,955.3	1,978,964.8
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,346,492.2	1,285,093.9
210101	Үндсэн цалин	956,203.6	910,025.4
210102	Нэмэгдэл	282,116.7	272,128.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,819.0	3,957.0
210104	Урамшуулал	102,352.9	98,983.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	175,836.8	168,220.8
210201	Тэтгэврийн даатгал	121,747.2	117,802.4
210202	Тэтгэмжийн даатгал	13,280.1	12,917.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,254.8	9,749.0
210204	Ажилгүйдлийн даатгал	4,202.5	2,942.2
210205	Эрүүл мэндийн даатгал	26,352.2	24,809.6
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	186,795.7	179,262.1
210301	Гэрэл, цахилгаан	13,182.0	9,108.0
210302	Түлш, халаалт	171,756.1	168,403.1
210303	Цэвэр, бохир ус	1,857.6	1,751.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	72,211.3	70,387.3
210401	Бичиг хэрэг	7,976.7	7,969.2
210402	Тээвэр, шатахуун	34,240.7	34,052.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,094.3	4,829.2

210404	Ном, хэвлэл	1,750.0	1,396.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,514.2	10,614.1
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,635.4	11,525.4
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>80,407.5</b>	<b>77,230.2</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	19,938.9	19,917.7
210502	Хоол, хүнс	45,959.6	42,806.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	14,509.0	14,505.8
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>63,240.0</b>	<b>63,235.6</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	39,797.3	39,797.2
210604	Урсгал засвар	23,442.7	23,438.4
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,898.0</b>	<b>3,816.0</b>
210702	Дотоод албан томилолт	5,898.0	3,816.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,335.7</b>	<b>11,109.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,930.0	6,926.8
210803	Даатгалын үйлчилгээ	1,162.8	1,032.5
210804	Тээврийн хэрэгслийн татвар	522.4	401.4
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77.0	55.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,504.7	1,755.0
210807	Газрын төлбөр	338.8	138.8
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	800.0	800.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>176,738.1</b>	<b>120,609.5</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	167,589.5	111,479.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,148.6	9,129.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51,920.5</b>	<b>51,582.3</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>51,920.5</b>	<b>51,582.3</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,368.4	36,116.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	11,446.9	11,446.9
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,105.2	4,018.6
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>118,779.9</b>	<b>53,398.2</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>118,779.9</b>	<b>53,398.2</b>
223001	Бусад хөрөнгө	118,779.9	53,398.2
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>102,718.0</b>	<b>82,000.0</b>
230001	Эргэж төлөгдөх зээл	102,718.0	82,000.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,393,373.7</b>	<b>2,240,035.3</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,419,795.9</b>	<b>1,382,310.8</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,335,925.2	1,298,440.1
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	83,870.7	83,870.7
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>702,611.1</b>	<b>669,841.3</b>
122005	Орон нутгийн төсвөөс	702,611.1	669,841.3
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>31,298.5</b>	<b>19,586.4</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	31,298.5	19,586.4
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>239,668.2</b>	<b>168,296.7</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.0	114,997.1
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	80,000.0	53,299.7

1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	69,668.2	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	69,591.6
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	140,712.9
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	6.00	6.00
610001	Төсвийн байгууллага	6.00	6.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	112.00	112.00
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	70.00	70.00
620003	Үйлчлэх ажилтан	32.00	32.00
620004	Гэрээт ажилтан	2.00	2.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	395,548.5
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	395,548.5
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	364,848.5
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	62,783.5
210101	Үндсэн цалин	56,113.5
210104	Урамшуулал	6,670.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	5,622.7
210201	Тэтгэврийн даатгал	2,439.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,270.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	484.7
210204	Ажилгүйдлийн даатгал	42.5
210205	Эрүүл мэндийн даатгал	385.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,495.3
210301	Гэрэл, цахилгаан	195.3
210303	Цэвэр, бохир ус	9,300.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,179.1
210401	Бичиг хэрэг	1,449.6
210402	Тээвэр, шатахуун	1,941.9
210404	Ном, хэвлэл	148.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,639.6
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	171,124.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	161,095.8
210502	Хоол, хүнс	10,028.4
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,899.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,899.8
210604	Урсгал засвар	7,999.8
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	26,167.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,167.3
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	47,796.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	45,876.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,920.0

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	30,700.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	30,700.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,700.0
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,780.9
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	7,780.7
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	0.2
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	397,585.6
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	397,585.6
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,244.4
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	361,485.6
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	32,855.6
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	2,037.1

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 01/18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Дундговь аймгийн Адаацаг сум нь эрхэм зорилгоо “Төр иргэний оролцоог ил тод нээлттэй болгож иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн бодлогыг шударгаар хэрэгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас сумын төсвийн 4 байгууллагын эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,157,050.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 31,570.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 22,099.4 мянган төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 862,397.6 мянган төгрөгөөр буюу 20.0 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгө, авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1.

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	930,893.6	1,434,089.9	503,196.3
Мөнгөн хөрөнгө	103,929.1	403,205.6	299,276.5
Авлага	295,857.5	472,159.0	176,301.5
Бараа материал	531,107.0	558,725.4	27,618.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,399,102.5	3,758,303.8	359,201.3
Үндсэн хөрөнгө	3,399,102.5	3,758,303.8	359,201.3
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,329,996.1</b>	<b>5,192,393.8</b>	862,397.6
Нийт өр төлбөр	33,663.5	21,193.5	(12,470.0)
Богино хугацаат өр төлбөр	33,663.5	21,193.5	(12,470.0)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,296,332.6	5,171,200.3	874,867.6
Засгийн газрын хувь оролцоо	4,296,332.6	5,171,200.3	874,867.6
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>4,329,996.1</b>	<b>5,192,393.8</b>	862,397.6

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 299,276.5 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын дансанд агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого 191,116.8 мянган төгрөг орсонтой холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 176,301.5 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас цар тахлын эмчилгээний 218,087.7 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгон, Эрүүл мэндийн төв авлага үүсгэн бүртгэсэнтэй холбоотой.

Бараа материалын үлдэгдэл 558,725.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 27,618.3 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн төвийн цар тахлын эм тариа, вакцин, вакцинжуулалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах эм, боох, хамгаалах хэрэгслийн үлдэгдэл өмнөх оноос 35,018.3 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 45,024.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном худалдан авч, хандиваар 529,076.9 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээс 118,708.9 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авч 157,315.4 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 1,790.0 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,171,200.3 мянган төгрөг болж 874,867.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5.2 Орлого бүрдүүлэлт

Дундговь аймгийн Адаацаг сумын ИТХ-ын 2020 оны орон нутгийн төсөв батлах тухай 15 дугаар тогтоолоор Адаацаг сум тайлант онд 81,300.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 305,679.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 376 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого				
Хувь хүний орлогын албан татвар	21,000.0	31,099.5	10,099.5	148
Бууны албан татвар	1,400.0	1,440.0	40.0	102.9
Улсын тэмдэгтийн хураамж	2,500.0	2,597.9	97.9	103.9
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	600.0		-600.0	0
Газрын төлбөр	2,300.0	2,285.5	-14.5	99.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8,000.0	10,361.0	2,361.0	129.5
Агнуурын нөөц ашигласны төлбөр		191,116.8	191,116.8	
Малын тоо толгойн албан татвар	20,000.0	35,363.0	15,363.0	176.8
<b>Дүн</b>	<b>55,800.0</b>	<b>274,263.7</b>	<b>218,463.7</b>	
Татварын бус орлого				
Хадгаламжийн хүүгийн орлого	18,500.0	25,142.2	6,642.2	135.9
Торгуулийн орлого	6,000.0	6,273.5	273.5	104.6
Бусад орлого	1,000.0		-1,000.0	
<b>Дүн</b>	<b>25,500.0</b>	<b>31,415.7</b>	<b>5,915.7</b>	
<b>Нийт дүн</b>	<b>81,300.0</b>	<b>305,679.3</b>	<b>224,379.4</b>	

Эх сурвалж: Адаацаг сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Хувь хүний орлогын албан татварын орлого 10,098.5 мянган төгрөгөөр давсан нь үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлогыг төвлөрүүлсэнтэй холбоотой.

Газрын төлбөр 14.5 мянган төгрөгөөр тасарсан нь тус суманд газрын даамлын сул орон тоо нөхөгдөөгүй, хариуцсан албан хаагч байхгүйгээс төлбөр ногдуулалт хийгдээгүйтэй холбоотой байна.

Агнуурын нөөц ашигласны төлбөр төлөвлөгөө байхгүй боловч Арабын хун тайжтай 8-р сард гэрээ байгуулан 7 шонхрын зөвшөөрөл олгон 191,116.8 мянган төгрөгийн орлого оруулсан.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 600.0 мянган төгрөгөөр тасарсан нь ковид цар тахлын улмаас айл өрх албан байгууллагууд элс хайрга ашиглаагүйтэй холбоотой байна.

Бусад орлого 1,000.0 тасарсан нь тухайлан нэр заасан орлого байхгүйтэй холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Адаацаг сумын ИТХ-ын 2020 оны 15 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,311,804.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,311,804.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Адаацаг сумын ИТХ-ын 2021 оны 08 болон 09 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт 2 удаа өөрчлөлт хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 81,569.3 мянган төгрөгөөр өсгөн, 2,393,373.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Тус онд гарсан ковид-19 цар тахлаас шалтгаалан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хаасантай холбоотойгоор тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжилтийг хасан баталсан байсныг жилийн эцэст өсгөн баталжээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 2,393,373.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,171,875.8 мянган төгрөгийг урсгал зардалд, 118,779.9 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 102,718.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,419,795.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 702,611.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 31,298.5 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 170,000.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,382,310.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 669,841.3 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 19,586.4 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 168,296.8 мянган төгрөг, нийт 2,240,035.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 114,997.0 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 24,997.0 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, туслах үйл ажиллагааны орлого 53,299.6 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 26,770.4 мянган төгрөгөөр тасарч, нийт төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 1,703.4 мянган төгрөгөөр тасарсан байна.

Туслах үйл ажиллагааны орлогод Мал хамгаалах сангийн өвсний борлуулалтын орлого, төсөвт байгууллагуудын Ахмадын сангийн орлого ордог бөгөөд тайлант онд тендер шалгаруулалтаас шалтгаалан өвсний татан авалт төлөвлөсөн хэмжээнд хийгдээгүй, төсөвт

байгууллагууд Ахмадын санд орлого төвлөрүүлээгүйгээс туслах үйл ажиллагааны орлого тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,165,945.2 мянган төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний бусад зардалд 1,978,964.8 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 53,398.1 мянган төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан 45,265.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлж, 28,824.3 мянган төгрөг үлдсэн байна.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-г “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд хандив тусламжаар 3,244.4 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 361,485.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 32,855.6 мянган төгрөг, нийт 397,585.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 62,783.5 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 5,622.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 9,495.4 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 20,179.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 13,899.5 мянган төгрөг, нормативт зардал 171,124.1 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 26,167.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 47,796.1 мянган төгрөг, урсгал шилжүүлэгт 30,700.0 мянган төгрөг, нийт 387,767.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 7,780.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд байгалийн гамшигт үзэгдэлтэй, цар тахалтай холбоотой сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 3,244.4 мянган төгрөгийн хандив орж ирснээс 3,244.4 мянган төгрөгийг сумын онцгой комиссын хяналтын постын шатахуун, хоол хүнс, хамгаалах хэрэгсэл зэргийг худалдан авахад зарцуулжээ. Үндсэн хөрөнгөнд 150,000.0 мянган төгрөгийн дугуйт ачигч ковшийг Нийслэлийн онцгой байдлын газраас шилжүүлэн өгсөн байна.

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд Эрүүл мэндийн яамнаас нийт 201,765.4 мянган төгрөгийн эм, эмийн хэрэгслүүдийг аймгийн ЭМГ-аар дамжуулан сумын ЭМТ-д хуваарилсан байна. Хуваарилсан эмийн 24,302.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, вакцины орлогыг аваагүй, зарлагыг тусгаагүй байсныг аудитын явцад залруулсан.

Сумын Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дотуур байрны халаалтын төлбөрийг м.куб-ээр тооцож олгосныг 2022 оноос м.кв-аар тооцуулахаар болсон.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг дарга нь 2021 онд нийт 153 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулснаас 7 мэдээллийн хугацаа хоцроож, 1 мэдээллийг мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж үзлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол зөрчсөн зөрчлүүдийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Дундговь аймгийн Адаацаг сумын Цэцэрлэг нь тайлант онд төсвөөс тавилга эд хогшил худалдан авсан, Засаг даргын нөөц сангаас тэмдэглэлт ой, урлагийн наадам, уралдаан тэмцээнд зохион байгуулсан, Орон нутгийн хөгжлийн сангаас иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтаар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус хөрөнгө худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 */Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах/,* Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.4 */энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх/,* мөн тогтоолын 1.6 */ЗГ-ын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх/,* Төсвийн тухай хуулийн 60.3.1.-д */Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ/,*

60.3.6-д /Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ/ дахь заалтуудыг тус тус зөрчсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн ОНХС-ийн худалдан авалт нь төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт сумын Засаг даргын Тамгын газар, Цэцэрлэг нь нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт 9,803.2 мянган төгрөгийн 4 хугацаатай төлбөрийн акт, 29,960.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 6 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	4	9,803.2	4	9,803.2			100
Албан шаардлага	6	29,960.3	6	29,960.3			100
Зөвлөмж							
<b>Нийт</b>	<b>10.0</b>	<b>39,763.4</b>	<b>10.0</b>	<b>39,763.4</b>			<b>100</b>

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан төсвийн байгууллагуудын үндсэн хөрөнгө, бараа материалын зарцуулалтад дараагийн завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 99,623.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 14,043.9 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 7,223.5 мянган төгрөгийн 2 алдааг буцаан төлүүлэх төлбөрийн акт, 25,830.6 мянган төгрөгийн 11 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага, цаашид анхаарч ажиллах 1 асуудалд 52,525.0 мянган төгрөгийн зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 85.9 хувийг залруулагдаагүй, 14.1 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Алдаа зөрчлийг ангиллаар нь харуулбал ихэнх буюу 25,097.1 мянга буюу 25.2 хувь нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай, 67,882.0 мянга буюу 68.1 хувь нь хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой, 6,643.9 мянга буюу 6.7 хувь нь дотоод хяналт

хариуцлагатай холбоотой алдаа, зөрчил тус тус илэрсэн байгаа нь дотоод хяналтыг сайжруулан, удирдлагуудын хууль, эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлж, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөн ажиллуулах шаардлагатай байгааг харуулж байна.

#### 4.1 Залруулсан алдаа

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд ерөнхий боловсролын сургуулийн төвлөрүүлэх шилжүүлэг 1,555.2 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд устгаагүй алдаа илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54.3.-т /Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана/ зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх зөрчлийг аудитын явцад залруулсан.

#### 4.2 Албан шаардлага

1. Байгаль хамгаалах сангийн 200,000 төгрөгийн хувь хүнээс авах авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/, мөн хуулийн 20.2.6-д /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/ заасныг тус тус зөрчсөн.

**Шийдвэрлэсэн нь:** Дээрх зөрчлийг дахин давтан гаргуулахгүй байхаар 200.0 мянган төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

#### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орон нутгийн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

**Илрүүлэлт:**

Сумын ИТХ-ын 2021 оны 09 дугаар тогтоолоор 2021 оны төсөвт тодотгол хийхдээ эд хогшил, урсгал засварын зардлыг 52,525.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 63,240.0 мянган төгрөг болгон баталж Засгийн газрын 2021 оны 2-р сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоолын 1.1-т /*үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлигүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*/, 1.4 /*энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх*/ заасныг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:**

Орон нутгийн төсөвт тодотгол хийхдээ холбогдох хууль, тогтоомжийг баримтлан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж, зарцуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 7 дугаар сарын 25 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
1	ЗДТГ	1	4,217.0					1	4,217.0		
2	ЕБС	1	0.0					1	0.0		
3	СОЁЛ	1	1,850.0					1	1,850.0		
4	ОНХС	1	9,290.0					1	9,290.0		
5	ОННТ	1	52,525.0							1	52,525.0
	<b>дүн</b>	<b>5</b>	<b>67,882.0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>4</b>	<b>15,357.0</b>	<b>1</b>	<b>52,525.0</b>
<b>2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:</b>											
1	ЗДТГ	2	1,376.6					2	1,376.6		
2	ИТХ	1	1,132.7					1	1,132.7		
3	ЭМТ	2	3,741.3			1	606.0	1	3,135.3		
4	ЕБС	1	4,235.7					1	4,235.7		
5	ЦЭЦЭРЛЭГ	2	4,313.9	1	3,920.5			1	393.4		
6	СХС	1	6,617.5			1	6,617.5				
7	ОНХС	1	8,568.2	1	8,568.2						
8	БХС	1	200.0					1	200.0		
9	ОННТ	1	1,555.2	1	1,555.2						
	<b>Дүн</b>	<b>12</b>	<b>31,741.0</b>	<b>3</b>	<b>4,043.9</b>	<b>2</b>	<b>7,223.5</b>	<b>7</b>	<b>10,473.6</b>	<b>-</b>	<b>-</b>
	<b>Нийт зөрчлийн дүн</b>	<b>17</b>	<b>99,623.0</b>	<b>3</b>	<b>14,043.9</b>	<b>2</b>	<b>7,223.5</b>	<b>11</b>	<b>25,830.6</b>	<b>1</b>	<b>52,525.0</b>